



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Чандмань сумын эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ХОА-2022/72/НА/СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Ховд хот 2022 он</p>	<p>Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар Утас: 70433061 Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn Аудитын менежер: А.Цэцэгсүрэн Утас:70432545 Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn Аудитор: Б.Должинжав Утас: 89898557 цахим хаяг: Doljinjavb@audit.gov.mn</p>
--------------------------------------------------------------------------------------------------	-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

ЧАНДМАНЬ СУМЫН ЭРҮҮЛ
МЭНДИЙН ТӨВИЙН ЭРХЛЭГЧ
Т.МЯТАВСҮРЭН ТАНАА

2022.02.25 № 2/88
танай _____-ны № _____-т

ЗӨРЧИЛГҮЙ ДҮГНЭЛТ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Чандмань сумын эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Чандмань сумын эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Х.БОЛДБААТАР

021020219

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
3. Аудитын тайлан	11
3.1 Ерөнхий зүйл	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Материаллаг байдал	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	13
3.8 Аудитын гол асуудал	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	14
4. Аудитын илрүүлэлт.....	14
4.1 Залруулсан алдаа	14
4.2 Албан шаардлага	15
4.3 Зөвлөмж	Error! Bookmark not defined.
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	15

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТШЗ	Төсвийн шууд захирагч
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
НА	Нотлох ажил

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Төгрөгөөр

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	17,459,888.48	83,549,549.10
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	26.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	26.00
3121	Төгрөг	-	26.00
31211	Төрийн сангийн харилцах	-	26.00
33	АВЛАГА	818,893.42	70,821,972.36
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	609,679.98	7,242,472.36
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	-	63,579,500.00
335	Бусад авлага	209,213.44	-
3351	Байгууллагаас авах авлага	0.44	-
3352	Хувь хүмүүсээс авах авлага	209,213.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	16,640,995.06	12,727,550.74
351	Түүхий эд материал	7,984,959.06	6,655,114.65
35130	Эм боох материал	7,984,959.06	6,655,114.65
354	Хангамжийн материал	6,476,036.00	6,072,436.09
35410	Бичиг хэргийн материал	767,550.00	-
35420	Аж ахуйн материал	-	2,286,760.00
35460	Хүнсний материал	176,316.00	1,254,960.00
35470	Бусад хангамжийн материал	5,532,170.00	2,530,716.09
35600	Мал амьтад	2,180,000.00	-
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,382,393,571.23	1,308,716,792.04
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,382,393,571.23	1,308,716,792.04
392	Биет хөрөнгө	1,367,304,821.31	1,293,742,292.20
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,314,272,785.00	1,314,272,785.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(89,899,845.68)	(165,930,437.96)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	107,938,987.00	79,986,844.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(47,544,594.99)	(27,985,055.87)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	111,547,681.00	132,928,828.09
39206	Хуримтлагдсан элэгдэл	(65,126,735.50)	(71,209,065.38)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	68,406,818.00	68,406,818.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(32,340,273.52)	(36,778,423.68)
39217	Ном	50,000.00	50,000.00
393	Биет бус хөрөнгө	15,088,749.92	14,974,499.84
39301	Програм хангамж	732,000.00	732,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(389,250.08)	(503,500.16)
39303	Бусад биет бус хөрөнгө	14,746,000.00	14,746,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,399,853,459.71	1,392,266,341.14
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	3,155,278.03	23,720,986.40
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	3,155,278.03	23,720,986.40
413	Өглөг	3,155,278.03	23,720,986.40
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	492,513.33	-
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	2,500,000.00	23,720,986.40
4136	Бусад өглөг	162,764.70	-
41361	Байгууллагад төлөх өглөг	162,764.70	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,396,698,181.68	1,368,545,354.74
51	Засгийн газрын хувь оролцоо	1,396,698,181.68	1,368,545,354.74

511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	214,581,860.80	214,581,860.80
51101	Өмч: - төрийн	214,581,860.80	214,581,860.80
512	Хуримтлагдсан үр дүн	855,333,527.45	827,180,700.51
51210	Өмнөх үеийн үр дүн	855,333,527.45	855,333,527.45
51220	Тайлант үеийн үр дүн	-	(28,152,826.94)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	326,782,793.43	326,782,793.43
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,399,853,459.71	1,392,266,341.14

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,474,187,522.00	710,439,687.18
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,035,134,878.00	40,532,004.18
120	Нийтлэг татварын бус орлого	1,035,134,878.00	40,532,004.18
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,035,134,878.00	40,532,004.18
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,035,134,878.00	40,532,004.18
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	439,052,644.00	669,907,683.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	368,244,000.00	410,209,900.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	368,244,000.00	410,209,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	14,134,360.00	202,350,751.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,050,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	13,084,360.00	202,350,751.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	26,985,900.00	26,312,325.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	26,985,900.00	26,312,325.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	29,688,384.00	31,034,707.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	29,688,384.00	31,034,707.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	534,368,076.92	736,412,514.12
21	УРСГАЛ ЗАРДАЛ	534,368,076.92	736,412,514.12
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	534,368,076.92	702,612,514.12
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	295,844,437.00	359,255,009.60
210101	Үндсэн цалин	206,501,282.00	227,225,111.30
210102	Нэмэгдэл	67,693,952.00	101,574,372.47
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,200,000.00	4,914,000.00
210104	Урамшуулал	16,449,203.00	25,541,525.83
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	37,693,132.58	36,083,429.33
210201	Тэтгэврийн даатгал	25,910,862.07	25,564,994.50
210202	Тэтгэмжийн даатгал	3,048,336.71	2,767,710.32
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,421,869.36	2,194,008.18
210204	Ажилгүйдлийн даатгал	573,824.04	505,156.11
210205	Эрүүл мэндийн даатгал	5,738,240.40	5,051,560.22
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	26,082,100.00	25,836,025.80

210301	Гэрэл, цахилгаан	1,900,700.00	2,514,468.80
210302	Түлш, халаалт	23,850,900.00	23,261,557.00
210303	Цэвэр, бохир ус	330,500.00	60,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	24,818,979.00	31,300,345.00
210401	Бичиг хэрэг	2,323,879.00	2,949,050.00
210402	Тээвэр, шатахуун	18,992,600.00	25,510,795.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,502,700.00	2,000,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	564,000.00	840,500.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	1,435,800.00	-
2105	Нормативт зардал	42,954,128.10	135,089,609.81
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	29,665,428.10	120,627,053.81
210502	Хоол, хүнс	9,832,700.00	11,402,656.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,456,000.00	3,059,900.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	381,500.00	870,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	264,000.00	870,000.00
210604	Урсгал засвар	117,500.00	-
2107	Томилолт, зочны зардал	540,000.00	690,000.00
210702	Дотоод албан томиллолт	540,000.00	690,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,514,425.63	704,874.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,023,930.83	-
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	270,000.00	200,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	81,675.00	300,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	69,300.00	-
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	25,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	69,519.80	179,874.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	104,539,374.61	112,783,220.58
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,459,785.50	17,725,294.30
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	92,079,589.11	95,057,926.28
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	33,800,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	33,800,000.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	-	2,000,000.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	-	31,600,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	200,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	939,819,445.08	(25,972,826.94)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	675,000.00	2,180,000.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	675,000.00	2,180,000.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(675,000.00)	(2,180,000.00)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	939,144,445.08	(28,152,826.94)

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Төгрөгөөр

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2020 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	214,581,860.80	326,782,793.43	(83,810,917.63)	457,553,736.60
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	214,581,860.80	326,782,793.43	(83,810,917.63)	457,553,736.60
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	939,144,445.08	939,144,445.08
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	214,581,860.80	326,782,793.43	855,333,527.45	1,396,698,181.68
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	214,581,860.80	326,782,793.43	855,333,527.45	1,396,698,181.68
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	214,581,860.80	326,782,793.43	855,333,527.45	1,396,698,181.68
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(28,152,826.94)	(28,152,826.94)
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	214,581,860.80	326,782,793.43	827,180,700.51	1,368,545,354.74

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	438,508,219.00	606,328,183.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	438,508,219.00	606,328,183.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	368,244,000.00	410,209,900.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	368,244,000.00	410,209,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	14,134,360.00	138,771,251.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,050,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	13,084,360.00	138,771,251.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	26,441,475.00	26,312,325.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	26,441,475.00	26,312,325.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	29,688,384.00	31,034,707.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	29,688,384.00	31,034,707.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	438,508,219.00	606,328,157.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	438,508,219.00	606,328,157.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	438,008,219.00	572,528,157.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	288,125,700.00	353,266,401.20
210101	Үндсэн цалин	197,691,100.00	210,592,563.49

210102	Нэмэгдэл	65,759,500.00	111,087,537.71
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,808,000.00	6,048,000.00
210104	Урамшуулал	18,867,100.00	25,538,300.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	38,627,000.00	48,287,970.00
210201	Тэтгэврийн даатгал	27,181,900.00	31,642,200.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,861,300.00	3,330,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,289,000.00	2,664,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	572,300.00	666,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,722,500.00	9,984,370.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	25,857,100.00	25,836,025.80
210301	Гэрэл, цахилгаан	1,675,700.00	2,514,468.80
210302	Түлш, халаалт	23,850,900.00	23,261,557.00
210303	Цэвэр, бохир ус	330,500.00	60,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	24,820,800.00	31,284,055.00
210401	Бичиг хэрэг	2,400,000.00	2,100,000.00
210402	Тээвэр, шатахуун	18,950,800.00	23,236,555.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,720,000.00	2,000,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,750,000.00	3,947,500.00
2105	Нормативт зардал	37,420,160.00	103,234,422.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	26,420,160.00	90,734,422.00
210502	Хоол, хүнс	7,500,000.00	10,500,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,500,000.00	2,000,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,476,300.00	1,476,300.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,000,000.00	1,476,300.00
210604	Урсгал засвар	476,300.00	-
2107	Томилолт, зочны зардал	658,284.00	690,000.00
210702	Дотоод албан томилолт	658,284.00	690,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,058,675.00	712,374.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,200,000.00	-
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	200,000.00	200,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	81,675.00	300,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	77,000.00	-
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	25,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	500,000.00	187,374.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,964,200.00	7,740,609.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,964,200.00	7,740,609.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	500,000.00	33,800,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	500,000.00	33,800,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00	33,800,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	26.00
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	-	-
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-

	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	26.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	26.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	468,140,900.00	467,556,906.00	(583,994.00)
21	УРСГАЛ ЗАРДАЛ	468,140,900.00	467,556,906.00	(583,994.00)
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	467,940,900.00	467,356,906.00	(583,994.00)
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	333,074,700.00	332,598,807.00	(475,893.00)
210101	Үндсэн цалин	212,819,100.00	212,343,207.00	(475,893.00)
210102	Нэмэгдэл	88,669,300.00	88,669,300.00	-
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,048,000.00	6,048,000.00	-
210104	Урамшуулал	25,538,300.00	25,538,300.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	44,965,100.00	44,965,100.00	-
210201	Тэтгэврийн даатгал	31,642,200.00	31,642,200.00	-
210202	Тэтгэмжийн даатгал	3,330,700.00	3,330,700.00	-
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,664,600.00	2,664,600.00	-
210204	Ажилгүйдлийн даатгал	666,100.00	666,100.00	-
210205	Эрүүл мэндийн даатгал	6,661,500.00	6,661,500.00	-
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	25,944,100.00	25,836,025.00	(108,075.00)
210301	Гэрэл, цахилгаан	2,748,700.00	2,748,700.00	-
210302	Түлш, халаалт	23,135,400.00	23,027,325.00	(108,075.00)
210303	Цэвэр, бохир ус	60,000.00	60,000.00	-
2104	Хангамж, бараа материалын зардал	26,670,000.00	26,670,000.00	-

210401	Бичиг хэрэг	1,200,000.00	1,200,000.00	-
210402	Тээвэр, шатахуун	20,970,000.00	20,970,000.00	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,000,000.00	2,000,000.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,500,000.00	2,500,000.00	-
2105	Нормативт зардал	29,037,800.00	29,037,800.00	-
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	20,537,800.00	20,537,800.00	-
210502	Хоол, хүнс	6,500,000.00	6,500,000.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,000,000.00	2,000,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,476,300.00	1,476,300.00	-
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,000,000.00	1,000,000.00	-
210604	Урсгал засвар	476,300.00	476,300.00	-
2107	Томилолт, зочны зардал	1,060,500.00	1,060,500.00	-
210702	Дотоод албан томилолт	1,060,500.00	1,060,500.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	712,400.00	712,374.00	(26.00)
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	200,000.00	200,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	300,000.00	300,000.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	25,000.00	25,000.00	-
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	187,400.00	187,374.00	(26.00)
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,000,000.00	5,000,000.00	-
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,000,000.00	5,000,000.00	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	200,000.00	200,000.00	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	200,000.00	200,000.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	200,000.00	200,000.00	-
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	468,140,900.00	467,556,932.00	(583,968.00)
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	410,209,900.00	410,209,900.00	-
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	410,209,900.00	410,209,900.00	-
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	26,420,400.00	26,312,325.00	(108,075.00)

132001	Орон нутгийн төсвөөс	26,420,400.00	26,312,325.00	(108,075.00)
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	31,510,600.00	31,034,707.00	(475,893.00)
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	31,510,600.00	31,034,707.00	(475,893.00)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		26.00	26.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	-
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	-
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	24.00	25.00	1.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-
620002	Гүйцэтгэх ажилтан	18.00	18.00	-
620003	Үйлчлэх ажилтан	5.00	5.00	-
620004	Гэрээт ажилтан		1.00	1.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	14,134,360.00	138,771,251.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	14,134,360.00	138,771,251.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	14,134,360.00	105,171,251.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,000,000.00	23,990,465.00
210101	Үндсэн цалин	2,000,000.00	
210102	Нэмэгдэл		23,990,465.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	4,614,055.00
210401	Бичиг хэрэг		900,000.00
210402	Тээвэр, шатахуун		3,714,055.00
2105	Нормативт зардал	9,485,860.00	74,196,622.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	9,485,860.00	70,196,622.00
210502	Хоол, хүнс		4,000,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,648,500.00	2,370,109.00

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,648,500.00	2370109.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	33,600,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	33,600,000.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	-	33,600,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	14,134,360.00	138,771,251.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	14,134,360.00	138,771,251.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,050,000.00	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	13,084,360.00	138,771,251.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Чандмань сумын эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх дуусгавар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг аудитор Б.Должинжав 2022 оны 02 дугаар сарын 18-нээс 02 дугаар сарын 24-ны хооронд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 12 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Чандмань сумын эрүүл мэндийн төв нь “Ард иргэдэд эрүүл, аж төрөх ёсыг дадал хэвшил болгосон, нотолгоонд суурилсан, анхан шатны тусламж үйлчилгээг аюулгүй, чанартай үзүүлэхэд оршино” гэсэн эрхэм зорилго дэвшүүлэн ажиллажээ.

Тухайн онд Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас 2018-2020 оны санхүүгийн баримтад дотоод хяналтыг хэрэгжүүлэн ажилласан байна.

Тус байгууллагын нягтлан бодогч нь байгууллагын хэмжээнд мөрдөгдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан мөрдөн ажиллаж байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд аудитын зорилго оршино.

Чандмань сумын эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар бүртгэж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлан гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд суурь үзүүлэлтээр батлагдсан төсвийг сонгож, эрсдэлийн үнэлгээнээс хамаарч материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “бага” гэж үнэлсэн учир материаллаг байдлын түвшинг хамгийн ихээр буюу 2 хувиар тогтоосон.

Материаллаг байдлын түвшинг 2021 оны батлагдсан төсөв 468.1 сая төгрөгөөс 2 хувиар буюу 9.4 сая төгрөгөөр тооцож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 80 хувиар буюу 7.5 сая төгрөгөөр тогтоов.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Чандмань сумын эрүүл мэндийн төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 7.6 сая төгрөгөөр өссөний материаллаг нөлөө нь авлага, үндсэн хөрөнгийн данстай холбоотой байна.

Тайлант оны эхэнд мөнгөн хөрөнгийн үлдэгдэлгүй байсан ба оны эцэст 26 төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Авлага дансны оны эхний үлдэгдэл 0.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй байсан бол оны эцэст 70.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй болж 70.0 сая төгрөгөөр өссөн байна. Эцсийн үлдэгдэл дэх 70.8 сая төгрөгийн авлагын 63.6 сая төгрөг нь эрүүл мэндийн даатгалын сангаас ковид-19 санхүүжилт, 7.0 сая төгрөг нь НДШ, ХХОАТ-т оны эцэст илүү шилжүүлсэн авлага, 0,2 сая төгрөг нь ҮЭ-д илүү шилжүүлсэн авлага байна.

Бараа материал данс оны эхэнд 16.6 сая төгрөг байсан бол оны эцэст 10.7 сая төгрөг болж 5.9 сая төгрөгөөр өмнөх оноос буурсан үзүүлэлттэй байна. Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 159.3 сая төгрөгийн бараа материал худалдан авч, сумын онцгой комисс, Эрүүл мэндийн газраас 17.2 сая төгрөгийн бараа материал үнэ төлбөргүй хүлээн авч, 182.4 сая төгрөгийн материалыг үйл ажиллагаандаа зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгө дансны оны эхний үлдэгдэл 1617.7 сая төгрөг байсан ба тайлант онд Эрүүл мэндийн газар, сумын орон нутгийн хөгжлийн сангаас, иргэдийн хандиваар нийт 21.4 сая төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүй хүлээн авч, 27.9 сая төгрөгийн 2 нэр төрлийн хөрөнгийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021.12.15-ны 118 дугаар, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2022.01.25-ны Б/10 дугаар тогтоолоор тус тус данс бүртгэлээс хасаж, оны эцэст үндсэн хөрөнгийн данс 1611.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Өр төлбөр дансны оны эхний үлдэгдэл 3.1 сая төгрөг байсан ба оны эцэст 23.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй болж 20.6 сая төгрөгөөр өссөн байна. Эцсийн үлдэгдэл дэх 23.7 сая төгрөг нь 3 компанитай холбоотой эмийн өр байна.

Засгийн газрын оролцоо дансны оны эхний үлдэгдэл 1,396.7 сая төгрөг байсан ба оны эцэст 1,368.5 сая төгрөг болж тайлант онд 28.2 сая төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайланд нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтөөр өмнөх оны үр дүнд залруулга хийгдээгүй байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Чандмань сумын эрүүл мэндийн төвийн 2021 оны төсвийн нийт зардлыг анх 468.1 сая төгрөгөөр баталсан ба тодотголоор нийт дүнд өөрчлөлт ороогүй байна.

Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр 468.1 сая төгрөгийн 410.2 сая төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 26.4 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 31.5 сая төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэхээр баталжээ.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээс 410.1 сая төгрөгийн санхүүжилтийг бүрэн авч, орон нутгийн төсвөөс 26.3 сая, эрүүл мэндийн даатгалын сангаас 31.0 сая төгрөгийн санхүүжилт буюу нийт 0.6 сая төгрөг дутуу авсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 467.6 сая төгрөг буюу 99.9 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардлыг 0.5 сая, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 0.1 сая төгрөгөөр тус тус хэмнэснээс шалтгаалжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын эдийн засгийн ангилал тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу төсвийн байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар, эрүүл мэндийн даатгалын сангаас ковид-19 зардлын санхүүжилт 106.2 сая, Эрүүл мэндийн газраас 32.5 сая нийт 138.7 сая төгрөгийн орлогын эх үүсвэр бүрдүүлэн, дээрх эх үүсвэрийг холбогдох арга хэмжээнд зарцуулжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын эдийн засгийн ангилал тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

АДБОУС 706.7-д тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулах дараах асуудал байна.

Тухайн байгууллага 2019 оны 10 дугаар сард нэгдсэн халаалтын шугамд холбогдсонтой холбоотой Эрдэс тайга ХХК-д дулааны гэрээний 44.8 сая төгрөгийн өр төлбөр үүсэж, батлагдсан төсвийн хязгаараас шалтгаалж төлөгдөөгүй учир шүүхийн байгууллагад маргаантай хэвээр байна.

3.8 Аудитын гол асуудал

АДБОУС 701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс 150 мэдээллийг хугацаанд нь, 1 мэдээллийг хугацаа хоцроож, 2 мэдээллийг хангалтгүй, 1 мэдээллийг огт мэдээлээгүй байна.

Үүнд: Санхүүгийн тайлан хагас жилээр мэдээлэх хэсэгт цэвэр хөрөнгө өмчийн өөрчлөлтийн тайлан хавсаргасан, аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлангийн хэсэгт 2019 оны аудитын зөвлөмж, хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг мэдээлсэн, санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт мэдээлээгүй зэрэг зөрчлүүдийг аудитын явцад залруулж, зөрчлийг арилгууллаа.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 4 зөвлөмжийн хэрэгжилт 60 хувьтай биелсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар албан шаардлагын биелэлтийг анхаарч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 174.6 сая төгрөгийн 6 алдаа зөрчил илэрснээс 166.7 сая төгрөгийн 3 алдаа, зөрчлийг аудитын явцад залруулж, 7.0 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 1 зөрчилд албан шаардлага, 0.9 сая төгрөгийн 1 зөрчилд зөвлөмж өглөө.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Дуудлага худалдаагаар худалдагдсан 27.9 сая төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлээс хасаж тайлагнаагүй.
2. Санхүүгийн үр дүн болон мөнгөн гүйлгээний тайланд 138.8 сая төгрөгийн нэмэлт санхүүжилтийн орлогыг үндсэн дансны ЭМДС-ийн санхүүжилт, бусад орлогын ангиллаар буруу тайлагнасан
3. Шилэн дансны цахим мэдээллийн санд дутуу мэдээлсэн мэдээллийг аудитын явцад нөхөж оруулсан.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад санхүүгийн тайланд нийт 166.7 сая төгрөгийн залруулга хийхийг шалгагдагч байгууллагын удирдлагад асуудлын бүртгэлээр танилцуулж, шалгагдагч байгууллага тухайн бүртгэлийг залруулан 2022 оны 02 дугаар сарын 25-ны 20 тоот албан бичгээр хариу ирүүлсэн.

4.2 Төлбөрийн акт

Цалингийн сангийн хэмнэлт 7.0 сая төгрөгийг оны эцэст НДШ, ХХОАТ-т илүү шилжүүлж авлага үүсгэсэн

Шийдвэрлэсэн: Энэ нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7-д “Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ” 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалтуудтай тус тус нийцээгүй тул төлбөрийн акт тогтоов.

4.3 Албан шаардлага

1. Эмийн тайлангийн зарлагын түүвэр 3 сараас хойш байхгүй, хяналт хийж тооцоо бодоогүй, эм авсан тухай бүрдээ хүлээн авсан эд хариуцагчийн гарын үсэгтэй орлогын баримт байхгүй, шатахууны тооцоог дуудлагын бүртгэлтэй тулгаж хянаагүй, өвчтөн илгээх хуудас, нотлох анхан шатны баримтгүйгээр шатахуун олгодог, шатахууны тооцоог нягтлан бодогч тооцоо бодож хянадаггүй, хөтөлбөрийн санхүүжилтээр авч буй бараа материалын тооцоог нярвын тайланд тусгадаггүй, эд хөрөнгийн тооллогыг чанартай зохион байгуулаагүй, тооллогын үр дүнг тооцоо бодож акт үйлдээгүй, нярвын тайлан, бараа материалын зарцуулалтад бүртгэлээр тавих хяналт сул байна.

Шийдвэрлэсэн: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “Нягтлан бодогч нь дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас өмнө хянан, баталгаажуулах үүрэгтэй”, 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д төсвийн зарчимд “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төсвийн шууд захирагч нь 6.5.1-д “төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах”, 6.5.4-д “төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх” гэсэн заалтуудтай тус тус нийцээгүй, өмнөх оны зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй тул албан шаардлага өгөв.

2. Эрхлэгч эмчид сар бүр хөдөлмөрийн нөхцөлийн нэмэгдэл сар бүр 10 хувиар тооцон нийт 0.9 сая төгрөгийн нэмэгдэл цалин бодож олгосон.

Шийдвэрлэсэн: Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолоор батлагдсан Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагчид хөдөлмөрийн нөхцөлийн нэмэгдэл олгох журамд нийцээгүй тул зөрчлийг таслан зогсоох албан шаардлага өгөв.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		/сая төгрөгөөр/							
				Үүнээс				Зөвлөмж			
		Тоо	Дүн	Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Тоо	Дүн
1	Чандмань ЭМТ	6	174.6	3	166.7	1	7.0	2	0.9		

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

Х.БОЛДБААТАР

АУДИТЫН МЕНЕЖЕР:

А.ЦЭЦЭГСҮРЭН

ТАЙЛАНГ БИЧСЭН:

АУДИТОР:

Б.ДОЛЖИНЖАВ

Чандмань сумын эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

4.2 Төлбөрийн акт

Цалингийн сангийн хэмнэлт 7.0 сая төгрөгийг оны эцэст НДШ, ХХОАТ-т илүү шилжүүлж авлага үүсгэсэн

Шийдвэрлэсэн: Энэ нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7-д “Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ” 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалтуудтай тус тус нийцээгүй тул төлбөрийн акт тогтоов.

4.3 Албан шаардлага

1. Эмийн тайлангийн зарлагын түүвэр 3 сараас хойш байхгүй, хяналт хийж тооцоо бодоогүй, эм авсан тухай бүрдээ хүлээн авсан эд хариуцагчийн гарын үсэгтэй орлогын баримт байхгүй, шатахууны тооцоог дуудлагын бүртгэлтэй тулгаж хянаагүй, өвчтөн илгээх хуудас, нотлох анхан шатны баримтгүйгээр шатахуун олгодог, шатахууны тооцоог нягтлан бодогч тооцоо бодож хянадаггүй, хөтөлбөрийн санхүүжилтээр авч буй бараа материалын тооцоог нярвын тайланд тусгадаггүй, эд хөрөнгийн тооллогыг чанартай зохион байгуулаагүй, тооллогын үр дүнг тооцоо бодож акт үйлдээгүй, нярвын тайлан, бараа материалын зарцуулалтад бүртгэлээр тавих хяналт сул байна.

Шийдвэрлэсэн: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “Нягтлан бодогч нь дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас өмнө хянан, баталгаажуулах үүрэгтэй”, 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д төсвийн зарчимд “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төсвийн шууд захирагч нь 6.5.1-д “төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах”, 6.5.4-д “төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх” гэсэн заалтуудтай тус тус нийцээгүй, өмнөх оны зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй тул албан шаардлага өгөв.

2. Эрхлэгч эмчид сар бүр хөдөлмөрийн нөхцөлийн нэмэгдэл сар бүр 10 хувиар тооцон нийт 0.9 сая төгрөгийн нэмэгдэл цалин бодож олгосон.

Шийдвэрлэсэн: Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолоор батлагдсан Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагчид хөдөлмөрийн нөхцөлийн нэмэгдэл олгох журамд нийцээгүй тул зөрчлийг таслан зогсоох албан шаардлага өгөв.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		/сая төгрөгөөр/							
				Үүнээс							
		Тоо	Дүн	Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
1	Чандмань ЭМТ	6	174.6	3	166.7	1	7.0	1	0.9		

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:  Х.БОЙДБААТАР

Аудитын код: ХОА-2022/72/НА-СТА-ТШЗ...





**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ**

2022 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 25/A2170428

Ховд

ХОА-2022/72/НА/-СТА-ТШЗ

ТӨЛБӨР БАРАГДУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Чандмань сумын эрүүл мэндийн төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан баталгаажуулах аудитаар цалингийн сангийн хэмнэлт 7002529 төгрөгийг оны эцэст НДШ, ХХОАТ-т илүү шилжүүлж авлага үүсгэсэн зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7-д "Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ" 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалтуудтай тус тус нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгаагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Дээрх зөрчилтэй холбоотой 7002529 /Долоон сая хоёр мянга таван зуун хорин есөн төгрөг /-ийг төрийн сангийн бусад нэр зааж ангилагдаагүй орлогын 100160000955 тоот дансанд 2022 оны 03 дугаар сарын 15-ны дотор төвлөрүүлэх.
2. Актын биелэлтийг 2022 оны 03 дугаар сарын 25-ны дотор Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Чандмань сумын эрүүл мэндийн төвийн эрхлэгч Т.Мятавсүрэн, нягтлан бодогч Б.Янжиндулам нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

А.ЦЭЦЭГСҮРЭН

АУДИТОР

Б.ДОЛЖИНЖАВ



1

¹ Монгол Улс, Ховд аймаг, Жаргалант сум, Цамбагарав баг, Засаг даргын Тамгын газрын байр, 3 давхар Утас: 70433061



ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 7/А217-0428

Ховд

ХОА-2021/721-СТА-ТШЗ

ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Чандмань сумын эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайланд аудит хийхэд эмийн тайлангийн зарлагын түүвэр 3 сараас хойш байхгүй, хяналт хийж тооцоо бодоогүй, эм авсан тухай бүрдээ хүлээн авсан эд хариуцагчийн гарын үсэгтэй орлогын баримт байхгүй, шатахууны тооцоог дуудлагын бүртгэлтэй тулгаж хянаагүй, өвчтөн илгээх хуудас, нотлох анхан шатны баримтгүйгээр шатахуун олгодог, шатахууны тооцоог нягтлан бодогч тооцоо бодож хянадаггүй, хөтөлбөрийн санхүүжилтээр авч буй бараа материалын тооцоог нярвын тайланд тусгадаггүй, эд хөрөнгийн тооллогыг чанартай зохион байгуулаагүй, тооллогын үр дүнг тооцоо бодож акт үйлдээгүй, нярвын тайлан, бараа материалын зарцуулалтад бүртгэлээр тавих хяналт сул, өмнөх онд өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй зөрчил илэрлээ.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "Нягтлан бодогч нь дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас өмнө хянан, баталгаажуулах үүрэгтэй", 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д төсвийн зарчимд "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төсвийн шууд захирагч нь 6.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", 6.5.4-д "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх" гэсэн заалтуудтай тус тус нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "шалгаагдах этгээд хууль тогтоомж, захирааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө." гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Дээрх зөрчлийг таслан зогсоож биелэлтийг 2021 оны 05 дугаар сарын 25-ны дотор Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт¹ ирүүлэх.

2. Цаашид алдаа, зөрчлийг дахин давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Чандмань сумын эрүүл мэндийн төвийн эрхлэгч Т.Мятавсүрэн, нягтлан бодогч Б.Янжиндулам нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

А.ЦЭЦЭГСҮРЭН

АУДИТОР

Б.ДОЛЖИНЖАВ





ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 6/А.2140428

Ховд

ХОА-2021/72/-СТА-ТШЗ

ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Чандмань сумын эрүүл мэндийн төвийн 2020 оны санхүүгийн тайлан баталгаажуулах аудитаар эрхлэгч эмчид сар бүр хөдөлмөрийн нөхцөлийн нэмэгдэл 10 хувиар тооцон нийт 932935 төгрөгийн нэмэгдэл цалин бодож олгосон зөрчил илэрлээ.

Энэ нь Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолоор батлагдсан “Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагчид хөдөлмөрийн нөхцөлийн нэмэгдэл олгох журам”-д нийцээгүй нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

3. Дээрх зөрчлийг таслан зогсоож биелэлтийг 2021 оны 05 дугаар сарын 25-ны дотор Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт² ирүүлэх.
4. Цаашид алдаа, зөрчлийг дахин давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Чандмань сумын эрүүл мэндийн төвийн эрхлэгч Т.Мятавсүрэн, нягтлан бодогч Б.Янжиндулам нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН МЕНЕЖЕР А.ЦЭЦЭГСҮРЭН

АУДИТОР Б.ДОЛЖИНЖАВ



¹ Монгол Улс, Ховд аймаг, Жаргалант сум, Цамбагарав баг, Засаг даргын Тамгын газрын байр, 3 давхар Утас: 70433061